



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136, Утас: 7012-8801,
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,
<http://www.chd.mohs.mn>

2022.01.03 № 07
танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗАР БОЛОН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг
бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн
сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан
маягтын дагуу төв болон тусгай мэргэжлийн төв
эмнэлгүүдээс 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж байна.
• Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 5 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

132300000004

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар/

1. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Эмчийн үзлэг хийлгэхээр нийт 401 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо, 7 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 92% /369/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт1/.

**Хүснэгт 1 . Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн
хүлээгдэл**

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо	
		4-6 хоног	7-с дээш хоног
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	2	82
2	Толгой, хүзүүний мэс засал	3	47
3	Туяа	-	47
4	Хими	1	46
5	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	1	39
6	Ерөнхий мэс засал	5	28
7	Зүрх судас судлал	17	15
8	Хөхний төв	-	25
9	Ангиографи	-	24
10	Элэг судлал	3	6
11	Цээжний хөндийн мэс засал	-	8
12	Хөнгөвчлөх	-	1
13	Ерөнхий хавдар судлал	-	1
	Нийт	32	369

Эмэгтэйчүүдийн мэс засалд үзүүлэхээр 84, Толгой, хүзүүний мэс засалд үзүүлэхээр 50, Хими болон Туяа эмчилгээний үзлэгийн кабинетэд тус бүр 47 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоногоор нийт 111 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 27 үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 42, Зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 27, ходоод дурандуулахаар 19, хөхний зураг авахуулахаар 18, эхо оношилгоо хийлгэхээр 3, рентгенд харуулахаар 2 үйлчлүүлэгч тус бүр 4-с дээш хоног хүлээж байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй, нийт 648 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс ойролцоогоор 2 дахин, даруй 316 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 2/.

Хүснэгт 2 . Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо				
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	Нийт
1	Өдрийн хими	11	92	142	40	285
2	Хими	10	72	127	21	230
3	Ангиографи	2	6	26	3	37
4	Элэг, цэс, нойр булчирхайн мэс засал	1	10	16	2	29
5	Хөнгөвчлөх	2	2	9	3	16
6	Туяа		1	13	1	15
7	Дуран		4	6		10
8	Эмэгтэйчүүдийн мэс засал		1	9		10
9	Толгой, хүзүүний мэс засал		3	2	1	6
10	Ерөнхий мэс засал		1	5		6
11	Хөхний төв		2		1	3
12	Цээжний хөндийн мэс засал			1		1
	Нийт	26	194	356	72	648

Тус эмнэлэгт өдрийн болон хими эмчилгээ хийлгэхээр нийт 515 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байна. Үйлчлүүлэгчид 14-21 хоногийн давтамжтай товлотт хими эмчилгээ хийдэг нь хүлээгдэлтэй харагдахад нөлөөлсөн байна. Ангиографиийн тасагт хэвэхээр 37 үйлчлүүлэгч, Элэг, цэс, нойр булчирхайн мэс заслын тасагт хэвтэхээр 29 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь удаах хамгийн их хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд орж байна.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Нийт 101 үйлчлүүлэгч амбулаторийн 8 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 14 үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлал, Мэдрэл судлалын эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	4-6 хоног	4
		7-с дээш хоног	35
	Нийт		39
2	Мэдрэл судлал	4-6 хоног	2
		7-с дээш хоног	17

	Нийт		19
3	Бөөр судлал	4-6 хоног	1
		7-с дээш хоног	17
	Нийт		18
4	Эмэгтэйчүүд судлал	4-6 хоног	7
		7-с дээш хоног	4
	Нийт		11
5	Мэс засал судлал	4-6 хоног	4
		7-с дээш хоног	2
	Нийт		6
6	Уушиг судлал	4-6 хоног	3
		7-с дээш хоног	2
	Нийт		5
7	Зүрх судас судлал	4-6 хоног	1
		7-с дээш хоног	1
	Нийт		2
8	Чих хамар хоолой	7-с дээш хоног	1
	Нийт		1
	БҮГД	4-6 хоног	22
		7-с дээш хоног	79
	НИЙТ		101

Хүлээгдэлтэй байгаа үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 78% /79/ нь 7-с дээш хоног эмчид үзүүлэхээр хүлээж байна.

Эхо оношилгоо хийлгэхээр хамгийн их буюу нийт 19 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 18 нь 15-с дээш хоногоор хүлээгдэлтэй байна. Мөн MRI/CT хийлгэхээр 12 үйлчлүүлэгч, рентген зураг авахуулахаар 9 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Улсын хоёрдугаар төв эмнэлэгт лабораторийн шинжилгээ хийлгэхээр нийт 69 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 24 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн талаас илүү буюу 65% нь /45/ биохимийн шинжилгээ хийлгэхээр хүлээж байна. Орны хүлээгдлийн хувьд авч үзвэл, тус эмнэлгийн Мэс заслын тасаг хамгийн их хүлээгдэлтэй байна. Уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 121 үйлчлүүлэгч ор хүлээж байна /Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Мэс засал судлал	3-6 хоног	48
		7-14 хоног	52
		15-30 хоног	21
	Нийт		121
2	Чих, хамар, хоолой судлал	3-6 хоног	21
		7-14 хоног	29
		15-30 хоног	22
	Нийт		72
3	Зүрх судасны тасаг	3-6 хоног	25

		7-14 хоног	14
		15-30 хоног	20
	Нийт		59
4	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	25
		7-14 хоног	16
		15-30 хоног	7
	Нийт		48
5	Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасаг	3-6 хоног	12
		7-14 хоног	14
		15-30 хоног	14
	Нийт		40
6	Уламжлалт анагаах ухааны эмчилгээний тасаг	3-6 хоног	11
		7-14 хоног	12
		15-30 хоног	4
	Нийт		27
7	Мэдрэлийн мэс засал судлал	3-6 хоног	5
		7-14 хоног	5
		15-30 хоног	2
	Нийт		12
8	Бөөр судлал	3-6 хоног	4
		7-14 хоног	6
	Нийт		10
9	Мэдрэл судлал	3-6 хоног	5
		7-14 хоног	3
	Нийт		8
10	Урологи	7-14 хоног	2
	Нийт		2
	БҮГД	3-6 хоног	156
		7-14 хоног	153
		15-30 хоног	90
	НИЙТ		399

Чих хамар хоолойн тасагт хэвтэн эмчлүүлэхээр 72, Зүрх судасны тасагт эмчлүүлэхээр 59, Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт хэвтэхээр 48 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь хүлээгдэл ихтэй тусламж, үйлчилгээнд хамаарч байна. Үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 77% /309/ нь 3-14 хоногийн хугацаанд хэвтүүлэн эмчлэх ор хүлээжээ.

3. Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн зүрх судасны эмчид үзүүлэхээр 62 үйлчлүүлэгч 3 хоног хүлээж байгаа ба амбулаторийн бусад чиглэлийн үзлэг, лаборатори болон оношилгооны тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байгаа ба нийт 573 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь өмнөх сараас 68 үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. Чих хамар хоолойн тасагт хэвтэн эмчлүүлэхээр 441 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн 77%-ийг эзэлж байна. Зүрхний мэс засал, судасны мэс заслын тасагт хэвтэхээр 75, мэдрэлийн мэс заслын тасагт эмчлүүлэхээр 38 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 2 дахин буурсан дүнтэй байна. / Хүснэгт 5/

Хүснэгт 5. ШУГТЭ-ийн хамгийн их орны хүлээгдэлтэй 3 тасгийн мэдээ

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Чих хамар хоолойн тасаг	3-6 хоног	25
		7-14хоног	55
		15-30 хоног	160
		1 сараас дээш	201
		Нийт	441
2	Зүрхний мэс засал, судасны мэс заслын тасаг	3-6 хоног	5
		7-14хоног	10
		15-30 хоног	25
		1 сараас дээш	35
		Нийт	75
3	Мэдрэлийн мэс заслын тасаг	3-6 хоног	15
		7-14хоног	9
		15-30 хоног	11
		1 сараас дээш	3
		Нийт	38
	БҮГД		573 /100%/

4. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус төв нь амбулаторийн үзлэг болон лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэлгүй байна. Харин Арьс харшлын тасагт хэвтүүлэн эмчлүүлэхээр 12 үйлчлүүлэгч 3-6 хоног, Мөөгөнцрийн тасагт хэвтэхээр 1 үйлчлүүлэгч 7-14 хоногийн хүлээгдэлтэй байна.

5. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

Тус төв нь 12 сард хүлээгдэл ихтэй ажиллаж байна. Эмгэг сэтгэл судлалын үзлэгт хамрагдахаар 119 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж байна. Мөн Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 110 үйлчлүүлэгч 15-30 хоногийн хүлээгдэлтэй байгаа нь 11 сарын үзүүлэлтээс даруй 614 үйлчлүүлэгчээр буурсан байна.

6. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй, зөвхөн MRI/CT-ийн шинжилгээ хийлгэхээр 189 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байгаагийн талаас илүү буюу 62% нь 15-с дээш хоног хүлээж байна.

7. Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв нь хүлээгдэлгүй ажиллаж байна.

8. УНТЭ, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, амаржих газрууд болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.